

ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, АНХААРАХ АСУУДЛУУД

Хяналт шинжилгээний газар

МТШХХГ-ын хариуцан хэрэгжүүлэх 43 арга хэмжээ тусгагдсан.

2014 оны хагас жилийн байдлаар 50.6 хувийн биелэлттэй хэрэгжиж байна. Үүнээс:

- * 100 хувийн биелэлттэй арга хэмжээ - 1
- * 80-90 хувийн биелэлттэй арга хэмжээ - 10
- * 60-80 хувийн биелэлттэй арга хэмжээ - 7
- * 40-60 хувийн биелэлттэй арга хэмжээ - 6
- * 20-40 хувийн биелэлттэй арга хэмжээ - 5
- * 20-оос доош хувийн биелэлттэй арга хэмжээ - 8

Төлөвлөгөөт хугацааны хэрэгжилтийн байдлаар ангилвал:

- * Хугацаандаа хэрэгжиж байгаа арга хэмжээ - 19
- * Санхүүжилтийн асуудал шийдэгдвэл хугацаандаа хэрэгжих боломжтой арга хэмжээ - 13
- * Хэрэгжих боломж багатай арга хэмжээ - 11

Төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих боломжтой 12 арга хэмжээ:

№	Арга хэмжээ	Биелэлт
1	118.2 Улсын чанартай авто зам дагуу шилэн кабель суурилуулж, харилцаа холбооны хамрах хүрээг өргөжүүлнэ. /МТШХХГ, ЗТЯ/	2011, 2012 онуудад БНҮҮС-ийн хөрөнгөөр улсын чанартай 7000 гаруй км зам дагуу харилцаа холбооны үйлчилгээний хамрах хүрээний хайгуул хийгдсэн. Судалгаагаар 52 цэгт дэд бүтэц байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан ба үүнээс ач холбогдол өндөр бүхий 25 цэгт Улсын төсвийн хөрөнгөөр дэд бүтэц байгуулахаар төлөвлөсөн. 2014 онд 6 цэгт харилцаа холбооны дэд бүтэц байгуулахаар төлөвлөн “Улсын болон олон улсын чанартай авто зам дагуу үүрэн холбооны үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах” төслийн мэдээллийн маягт, хавсралтыг нэгтгэж Эдийн засгийн хөгжлийн яамны концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар саналаа өгсөн.
2	141.2 Орон нутагт мэдээлэл харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулна.	"Орон нутгийн мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах, ТН-01/12" төслөөр 2012 онд 8, 2013 онд 14, 2014 онд 13, 2015 онд 14 суманд нэг цэгийн төвийг байгуулах ба 2012 онд байгуулсан 8 төвийг байнгын ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн. Мөн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар 2013 онд Сүхбаатар аймгийн Дарьганга суманд нэг цэгийн үйлчилгээний төв байгуулсан. 2013 оноос эхлэн санхүүжилт тусгагдаагүй тул гэрээт ажил үргэлжлэх боломжгүй болж зогсоод байна.

3	141.4 Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбоно. /2013-2015, МТШХХГ/	Монгол Улсын нийт сумдаас шилэн кабельд холбогдоогүй 39 сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбохтой холбогдсон техникийн нөхцлийг судалж байна. Судалгаагаар шилэн кабель татах бололцоо бүхий 22, тоон радио релейгээр шийдэх 9, сумын төвд тоон радио релейний сүлжээ орсон 4, хоорондох зай хол 4 сум байна. Хол зай бүхий 4 сум нь шилэн кабель орсон эцсийн сумаасаа 150-290 км зайтай ба түүнийг тоон радио релей болон сансрын холбооны VSAT технологиор шийдэх боломжийг тодорхойлохоор ажиллаж байна. 2014 онд Улсын төсвөөс нэр бүхий 12 суманд шилэн кабель суурилуулахаар ажиллаж байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд шилэн кабельд холбогдоогүй 16 сумыг холбох санал хүргүүлсэн.
4	283.2 Шуудангийн үндсэн сүлжээний техник технологийн шинэчлэл хийж, цахим шуудангийн үйлчилгээ бий болгоно. /МТШХХГ/	Шуудангийн үндсэн сүлжээний техник технологийн шинэчлэл хийж, цахим шуудангийн үйлчилгээ бий болгох хүрээнд "Хот хоорондын шуудангийн тээвэр, хүргэлтийн автомашин нийлүүлэх", "Шуудангийн тээвэр, хүргэлтийн GPS суурьтай хяналтын систем нэвтрүүлэх", "Гар компьютер буюу PDA нийлүүлэх", "Мэдээллийн логистик-сүлжээний тоног төхөөрөмж худалдан авах" төслүүдийг бүрэн хэрэгжүүлж, "Ухаалаг шуудангийн хайрцаг суурилуулах" төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
5	283.7 Хэвлэлийн электрон хүргэлтийн систем бий болгоно. /2013-2015, МТШХХГ/	Өдөр тутмын хэвлэлийн эхийг орон нутагт файлаар нь дамжуулж хэвлэх технологийн боломж, холбогдох эдийн засгийн тооцог хийсэн. Хэвлэлийн цахим хүргэлтийн системийг бий болгох төслийг шинэчлэн боловсруулж, Зууны мэдээ сонины хэвлэлийн үйлдвэр дээр очиж хэвлэх процесттой танилцан, техник технологийн судалгаа хийж, шийдлийг боловсруулсан .
6	38.2 Өндөр нарийвчлал бүхий тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлнэ. /МТШХХГ, БХБЯ, БОНХЯ/	Төслийн ТЭЗҮ-г Падеко энд Эрсдак консерциум ХХК хийж дууссан. Тандан судалгааны хиймэл дагуул үйлдвэрлэгч, хөөргөгчийг сонгон шалгаруулах чиглэлээр БНХАУ-ын Хятадын сансрын технологийн академи, Япон улсын ЭЗХАҮЯ, Англи болон Япон улсуудын хамтарсан Эс Эс Ти Эл болон ЖАМСС компани , Франц улсын Астриум зэрэг компаниудтай уулзалт зохион байгуулсан. Монгол Улсын хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар Сансрын үндэсний зөвлөлийн хүрээнд хэлэлцүүлж, зохих зөвлөмж гаргуулахаар Монгол Улсын Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулга бэлтгэн хүргүүлсэн.

7	73.2 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгоно. /МТШХХГ, УХААЯ/	УХААЯ-наас "Бараа түүхий эдийн биржийг байгуулах" төслийг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн биржийн спот арилжааны захиалгын бүртгэлийн програмыг ажиллуулсан. Энэхүү системийг өргөтгөх орон нутгийн брокерууд, итгэмжлэгдсэн агуулахыг холбосон онлайн худалдаа хийх арилжаа, клиринг, төлбөр тооцооны цогц систем худалдан авах 3,7 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй тул төслийн ажил зогссон
8	118.2 Улсын чанартай авто зам дагуу шилэн кабель суурилуулж, харилцаа холбооны хамрах хүрээг өргөжүүлнэ. /МТШХХГ, ЗТЯ/	2011, 2012 онуудад БНҮҮС-ийн хөрөнгөөр улсын чанартай 7000 гаруй км зам дагуу харилцаа холбооны үйлчилгээний хамрах хүрээний хайгуул хийгдсэн. Судалгаагаар 52 цэгт дэд бүтэц байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан ба үүнээс ач холбогдол өндөр бүхий 25 цэгт Улсын төсвийн хөрөнгөөр дэд бүтэц байгуулахаар төлөвлөсөн. 2014 онд 6 цэгт харилцаа холбооны дэд бүтэц байгуулахаар төлөвлөн "Улсын болон олон улсын чанартай авто зам дагуу үүрэн холбооны үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах" төслийн мэдээллийн маягт, хавсралтыг нэгтгэж Эдийн засгийн хөгжлийн яамны концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар саналаа өгсөн.
9	141.3 Сумдад өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулна. /МТШХХГ/	"Сумдад өндөр хурдны түгээх сүлжээ байгуулах ТН-07/12" төслийн хүрээнд нийт 19 аймгийн 250 суманд өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах ба 2012 онд 16 аймгийн 38 сумын ЗДТГ, эмнэлэгийг шилэн кабелиар түгээх сүлжээнд холбож сумын төвд утасгүй интернэтийн бүс байгуулсан. 2013 онд Нийслэлийн 3 дүүрэг, 21 аймгийн төв болон 18 аймгийн 52 суманд тус ажлыг гүйцэтгээд байна. Интернэтийн үйлчилгээг БНҮҮС-аас хэрэгжүүлж байна. Шилэн кабельд холбогдсон сумдын орон нутгийн ЗДТГ, сургууль, эмнэлэг, соёлын төвийг интернетийн сүлжээнд холбох, иргэдийг WiFi утасгүй интернэтээр хангах ажлыг Монголын цахилгаан холбоо ХХК, МТШХХГ болон тухайн орон нутаг хамтраад энэ оны 9 дүгээр сарын 1-ний дотор дуусгахаар ажиллаж байна.
10	167.5 Эмийн аюулгүй байдлын мэдээллийн системийг нэвтрүүлнэ. /МТШХХГ, ЭМЯ, ХЗЯ, МХЕГ/	ЭМЯ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж судалгааг боловсруулж бэлэн болсон. Иргэдэд эрүүл мэндийн даатгалын ухаалаг цахим үнэмлэх олгох асуудлыг цахим иргэний үнэмлэхтэй холбох талаар хамтран ажиллаж байна. Мөн ЭМЯ-наас Эм борлуулах цэг буюу аптека байгуулах тусгай зөвшөөрлийг олгох системийг хийж хэрэгжүүлсэн. Програм хангамжийн үндэсний компаниудаас "Эмийн болон хүнсний аюулгүй байдлын систем"-ийн төслийг боловсруулан танилцуулсан боловч энэхүү ажлыг хэрэгжүүлэх төсөв суугаагүй болно.

11	267.7 "Бага оврын сансрын холбооны хиймэл дагуул" төсөл хэрэгжүүлнэ. /2012-2018, МТШХХГ, УУЯ, БХБЯ, ҮХААЯ/	Төслийн ТЭЗҮ-г Падеко энд Эрсдак концерциум ХХК хийж дууссан. Харилцаа холбооны хиймэл дагуул үйлдвэрлэгч, хөөргөгчийг сонгон шалгаруулах чиглэлээр БНХАУ-ын Хятадын сансрын технологийн академи, Япон улсын Sky Perfect, Франц улсын Астриум, Европын холбооны Талес Алена Спейс зэрэг компаниудтай уулзалт зохион байгуулсан. Монгол Улсын хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар Сансрын үндэсний зөвлөлийн хүрээнд хэлэлцүүлж, зохих зөвлөмж гаргуулахаар Монгол Улсын Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулга бэлтгэн хүргүүлсэн. 2013 онд санхүүжилт нь төсвийн хязгаараас шалтгаалан 2/3-аар хасагдсан. Үлдэгдэл санхүүжилтийг 2014 онд шийдвэрлэх шаардлагатай.
12	274.12 Төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайт бий болгоно. /2013-2018, МТШХХГ/	Төрийн үйлчилгээний нэгдсэн вэб порталын модулууд хөгжүүлэлт" төслийн хүрээнд програм хангамжийн нэгдсэн архитектурын зөвлөх үйлчилгээ явагдаж байна. Тус зөвлөх үйлчилгээнд үндэслэн 2014 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Замын цагдаагийн газар, Зам тээврийн яам, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын 25 төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэнэ.
13	283.1 Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Цахим засаглал, Цахим эрүүл мэнд төслүүдийг хэрэгжүүлнэ. /МТШХХГ, ЭМЯ/	МУ-ын Засгийн газар, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассациацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ухаалаг засаг", "Цахим эрүүл мэнд" төслийн санхүүжилтийн хэлэлцээртэй холбогдох асуудлаар Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл гарсан. Төслүүдийг хэрэгжүүлж байгаа талаар тодорхой мэдээлэл байхгүй.

Төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих боломж багатай 11 арга хэмжээ

№	Арга хэмжээ	Биелэлт
1	89.4 Үндэсний мэдээлэл, харилцааны технологийн судалгаа, хөгжлийн төвийг барьж байгуулна. /2013-2016; МТШХХГ, БШУЯ/	Тус газраас Оюуны бүтээмж-Өндөр цалинтай ажлын байр, дэлхийн стандартын E-бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтын хүрээнд Мэдээллийн технологийн үндэсний парк дээр хэрэгжүүлсэн “Силикон Хаус”-ын бүрэлдэхүүнд Эмбеддэд систем хөгжүүлэлтийн лаборатори, Компьютерийн вишн лаборатори, Мэдээллийн технологийн мэргэшлийн сургалтын төв, Мэдээллийн технологийн төрөлжсөн номын санг шинээр ашиглалтанд оруулсан.
2	89.5 Экспортод суурилсан эмбедэд /Embedded/ систем болон чипэд суурилсан системийн технологийн судалгаа хөгжлийн төв байгуулна. /2014-2017; МТШХХГ, БШУЯ/	Санхүүжилт байхгүй тасарсан ажил
3	89.6 Чип дизайны үйлдвэр байгуулна. /2012-2016; МТШХХГ, ЭЗХЯ, БШУЯ/	“Силикон Хаус”-ын бүрэлдэхүүнд байгуулагдсан Эмбеддэд системийн лабораторид Монголд анх удаа PCV хавтанг үйлдвэрлэх боломжтой болсон нь чип дизайны үйлвэрийн эхлэл болсон.
4	89.7 Дотоодын программ хангамжийн зах зээлийг хангах, олон улсын стандартад нийцсэн чанарын менежментийг нэвтрүүлнэ. /2014-2015, МТШХХГ/	Санхүүжилт байхгүй тасарсан ажил
5	247. 6 Байршил тогтоох навигацийн системийг хил хамгаалах үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. /2013-2015, МТШХХГ, ГХЯ, БХЯ, ХЗЯ/	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв суугаагүй ба Хил хамгаалах ерөнхий газарт хандан тус арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг 2014 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөөндөө тусган ажиллах талаар хүсэлт явуулсан.

6	281.1 Орчин үеийн шинэ технологи болох Үүлэн тооцооллыг /Клауд компьютеринг/ нэвтрүүлж, цахим-офисын орчин бүрдүүлнэ. /МТШХХГ, Төрийн байгууллага/	Цахим засаг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан Орчин үеийн шинэ технологи болох Үүлэн тооцооллыг нэвтрүүлэх төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан.
7	283.3 Цахим гарын үсгийн сертификатыг иргэний ухаалаг үнэмлэхэд суулгана. /2013-2015, МТШХХГ, УБЕГ/	Тус арга хэмжээг УБЕГ-т шилжүүлсэн. Иргэний ухаалаг үнэмлэхэд цахим гарын үсгийн PKI кодыг суулгах шаардлагатай ба тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах 800 сая төгрөгийн төсвийн асуудал хэрэгжүүлэгч талуудын төсөвт батлагдахгүй байгаа тул арга хэмжээ зогсоод байна.
8	283.4 Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа бүх шатны байгууллагуудын сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулна. /2013, МТШХХГ, Яам/	Төрийн үйлчилгээ үзүүлж буй бүх шатны байгууллагуудын сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэх санхүүжилт улсын төсөвт суугаагүй.
9	283.5 Төрийн бүх шатны байгууллага, түүний салбар нэгжүүдэд иргэний цахим үнэмлэх уншигч, тоног төхөөрөмж суурилуулж, программ хангамж нэвтрүүлнэ. /2013-2014, МТШХХГ, Яам/	Төрийн бүх шатны байгууллага, түүний салбар нэгжүүдэд иргэний цахим үнэмлэх уншигч, тоног төхөөрөмж суурилуулж, программ хангамж нэвтрүүлэх ажлын хөрөнгө нь төсөвт тусгагдаагүй ба урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлээд байна. Тус арга хэмжээг Улсын бүртгэлийн ерөнхий газар луу шилжүүлсэн. Иргэний ухаалаг үнэмлэхэд суурилуулагдах цахим гарын үсгийн PKI кодыг уншигч төхөөрөмжийг тус арга хэмжээний хүрээнд төрийн байгууллагуудад суурилуулах шаардлагатай ба үүнд шаардагдах 800 сая төгрөгийн төсөв батлагдаагүй тул арга хэмжээ хэрэгжээгүй болно.
10	247.5 Хилийн боомтуудыг холбосон “Өргөн зурвасын сүлжээнд суурилсан цогц удирдлага, хяналтын систем” бий болгоно. /2013-2014, МТШХХГ, ГХЯ, БХЯ, ХЗЯ/	Боомтын нэгдсэн захиргааны төвтэй хамтран хилийн боомт чөлөөт бүсүүдэд өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, цогц удирдлага, хяналтын систем бий болгох тооцоо судалгааг хийн төслийг боловсруулж, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулахаар ЭЗХЯ-руу санал хүргүүлсэн.
11	274.9 Үндэсний дата төвийг тоноглож, нөөц төв байгуулна. /2013-2015, МТШХХГ, ТЕГ/	Тус төвийн нөөц төвийг байгуулах байршлыг ТЕГ-аас тогтоосон. Дата төвийн нөөц төвийн ТЭЗҮ боловсруулах төслийг хэрэгжүүлэхээр 2015 оны улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна.